



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/365

Номгон

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг
түр хугацаагаар хориглох тухай


Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 08, 09, 10-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд 18-аас доош градустай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаагаар хориглосугай.

2. Энэ өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газрууд, аж ахуй нэгж, иргэдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, Цагдаагийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

621010925